

СОЦИАЛИСТ РЕАЛИЗМ БА СИСТЕМИЙН ХАНДЛАГА

Д.Галбаатар¹

Хэдийгээр хувьсгалын эхний үе шатанд МАХН-аас уран зохиол, ший жүжиг, соёлын асуудлыг өдөр тутмын удирдлагаар хангаж хөгжлийн чиг замыг тодорхойлон зааж асан ч туурвин бүтээх уран сайхны арга нь гол төлөв хуучин хэвээрээ байсан бөгөөд намаас ч нийгэм журмын реализм /социалист/-ын асуудлыг юун түрүүн дэвшүүлж тавиагүй бөгөөд намын VII их хурлын /1928/ заалтыг амьдралд хэрэгжүүлж “Уран үгсийн чуулган” Монголын Зохиолчдын Бүлгэм байгуулагдаж “Монголын хувьсгалт уран зохиол юуны өмнө МАХН-ын үйл хэргийн бүрэлдэхүүн гэж үзэж уран зохиолын нийгмийн шинж намч, ардач, ангич чанар, үзэл суртлын чиг шугамыг тодорхойлж “Уран бүтээлийн аргыг алив юмны үнэн байдал дээр бичих, алив үнэн хэргийг өөр сонин зүйлээр үлгэрлэж бичихийн зүйлүүд болмой” гэж томъёолсон бол 1930-аад оны дундуур хуралдсан МАХН-ын IX хурал Д.Нацагдорж, С.Буяннэмэх, Ц.Дамдинсүрэн, М.Ядамсүрэн, Ши.Аюуш, Д.Цэвэгмид зэрэг зохиолчдын бүтээлээр хувьсгалын уран зохиолын эхний 13 жилийн эрэл туршлагыг нэгтгэн дүгнэж “Үзэгдэж буй гадаргын чинад дахь үнэн байдлыг таньж бичих” шинэ зам /арга. Д.Г/ нээгдүүлснийг тэмдэглэж бүр 1939 оны МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн тогтоолоор монголын зохиолчдоос Марксизм-Ленинизмыг судлан сурч, намын үзэл суртал, улс төрийн бодлогын төвд байснаар хувьсгалт утга чанартай уран сайхны бүтээл туурвиж чадна гэж тодорхойлоод “Манай уран зохиолын нийгэм журмын үнэнийг баримталсан реализм нь хувьсгалын арга маяг ба түүний онол ухаан зорилтыг зөв үнэнээр илрүүлэн гаргах арга мөн. Энэхүү хувьсгалын уран сайхны ёс журмыг хэрэг дээрээ биелүүлэх тухай өргөн таниулгын ажлыг явуулж гүйцэтгэсүгэй” /1/ “ЗХУ-ын уран зохиолчдын холбоотой туйлын дотно холбоог байгуулах хэрэгтэй. Монголын залуу зохиолчдод тусламж үзүүлэх ба Монгол ард улсыг Зөвлөлт улсын уран зохиолд оруулан гаргах /тусган дүрслүүлэх Д.Г/ зорилгын үүднээс Холбоот улсын уран зохиолчдыг урин ирүүлэх” /мөн тэнд/ заалт өгчээ.

Энэ нь 1934 оны Зөвлөлтийн Бүх Холбоотын Зохиолчдын анхдугаар их хурлаас “социалист реализм”-ын аргыг тунхагласантай холбоотой манай уран зохиолын арга ч социалист реализм байх ёстойг заасан намын удирдамж байв. Нэг үгээр хэлбэл МАХН-ын баримт бичигт уран бүтээлийн цаашдын баримтлах аргыг анх цэгцтэй албан ёсоор томъёолсон нь энэ юм. Оросын социалист реализмын арга, онолын нөлөө энэ үеэс идэвхжиж эхлэсэн гэж болно.

Нөгөө талаар Зөвлөлтөд М.Горькийн нэрээр томъёологдсон “социалист реализм”-ын тунхаглал монголын үндэсний шинэ уран зохиолд түүний зөвлөсөн “идэвхтэй

¹ ШУ-ы доктор, профессор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

зарчим"-аас өөр уран бүтээлийн арга зүй бүрэлдээгүй байсан монголын уран зохиолын хүрээнд энэ шинэ мэдээ, итгэл найдварын оч болж ирсэн нь ойлгомжтой юм. Энэ үед уран бүтээлийн аргыг "Үнэн байдлаас үндэс авч уламжлан найруулах" арга гэж томъёолоод 1939 онд "Нийгэм журмын үнэнийг баримталсан реализм" гэж албан ёсоор нэрлэжээ. /Ц.Мөнх/ Энэ томъёолол ч цэвэр үндэсний уран зохиолын хөгжлийн дотоод үйл явцаас урган гарсангүй. 1938 онд орос, монгол зохиолчдын уран бүтээлийн семинар зохион байгуулж, түүн дээр театрын найруулагч, зөвлөлтийн мэргэжилтэн В.Борейшо уран сайхны талаар формализм, натурализм зэрэг олон янзын үзэл бийг дурдаад "Бид энэ хоёр үзлийг аль алийг ч үл баримтлана" Бид ямар үзлийг баримтлах вэ гэвэл "нөхөр Сталинаас уран сайхны ажлын... арга, маягийг хувьсгалт реализм хэмээн нэрийдсэн бөгөөд гагцхүү энэ арга маягийг баримталбал хувьсгалт уран сайхан зөвөөр бүтнэ" /2/ гэж хэлснийг "Үнэн" сонин хэвлэжээ.

Ийнхүү "хувьсгалт реализм" гэдэг нэр томъёо мөн л Сталины соёлын бодлоготой шууд холбоотой социалист реализм гэсэн утгаар орж ирсэн бөгөөд манай "нийгэм журмын үнэнийг баримталсан /хараахан нийгэм журмын реализм биш Д.Г./ реализм"-тай дүйцүүлж улмаар 1948 онд "хувьсгалт реализм"-ын зарчмуудыг МЗЭ-ийн анхдугаар их хурал үлгэр аван тодорхойлсон байна. Үүнээс үзэхэд Зөвлөлтийн утга зохиолын онолын сэтгэлгээний хөгжил, үзэл баримтлал 1934 оноос хойш тодорхой болж /дотооддоо олон урсгал, олон арга, бүлэглэлүүд тэмцэлдэж түүний эсрэг явуулсан улс төрийн бодлогын илэрхийлэл Д.Г/ монголын уран зохиол, залуу уран зохиолчдын учраа олохгүй байдал эцэслэж, хувьсгалт ба социалист реализмын зарчим, онол цаашид саадгүй хөгжих чиг баримжаа нь болжээ. Үүнд монголын зохиолчдын өөрсдийн идэвхтэй санаачлага чухал үүрэгтэй байв. 1925 оноос хойш /Горькийн захидал/ Монгол-Зөвлөлтийн зохиолчдын хооронд албан ёсны харилцаа хомс, Оросоос Монгол руу чиглэсэн соёлын бодлого тодорхой бус байсан бол зөвлөлтийн багш мэргэжилтнүүд театр, киноны салбарт ажиллаж, монголын сэхээтнүүд Орос-Зөвлөлтийн болон дэлхийн уран зохиолоос орчуулах, Улаан-Үд, Эрхүүгийн зохиолчдын төлөөлөгчид уригдан ирж түр хугацаагаар ажиллах, монгол зохиолчид Зөвлөлтөд аялах, туршлага судлах, хоёр тал руу орчуулах, зарим нэг зохиолыг хамтран бичих, жүжиг, кино зохиох зэрэг хамтын ажиллагаанд монголын зохиолчдын санал санаачилга голлох байртай байсан аж.

Харин 1930-аад оны дунд үеэс байдал өөрчлөгдөж, Орос Зөвлөлтийн дотоод дахь иргэний дайн түүнээс шууд улбаалан уран зохиол, урлагийн салбарт буй болсон хямралт байдлыг хүчээр дарж "социалист реализм"-ыг тунхаглаж чадсанаар дэлхий дээрх цор ганц дотно түнш-дүү Монголын соёл, урлаг, утга зохиолын салбарт социалист соёлын бодлогоо эрчимжүүлэх таатай нөхцөл бүрджээ. Ийнхүү социалист реализмын уран зохиол дангаар ноёлох нь дотоод гадаад хоёр хүчин зүйлээр нөхцөлдсөн бөгөөд гадаад хүчин зүйл нь Орос-Зөвлөлтийн урлагийн гол арга болох социалист реализм, дотоод хүч нь монгол зохиолчдын өөрсдийн идэвхтэй чармайлт болж байв.

1934 онд Зөвлөлтийн Бүх Холбоотын Зохиолчдын анхдугаар их хурал хуралдсан яг энэ үед /3/ Монголын үндэсний хувьсгалт уран зохиолчдын холбооны бүх гишүүдийн хурал хуралдаж III зүйлд "Манай холбооны нэрийн өмнөөс тусгай төлөөлөгчийг СССР улсад явуулж, тэндэхийн зохиолчид лугаа холбоо байгуулах ... алдарт их зохиолч М.Горькийд дурсгалын зүйл /мөнгөн бийр янтай, алтан үсэгт дурсгалын дэвтэр Д.Г/ хүргүүлэн заавар сургаал олох..."-оор М.Ядамсүрэнг төлөөлөгч

болгон явуулж “халуун журмын харьцаа” /4/ барихыг даалган илгээсэн баримт бичиг байдаг боловч М.Горькийтой уулзаж зөвлөлгөө авч чадсан эсэх нь тодорхойгүй байна. Ийнхүү МАХН-ын IX их хурлаас баталсан Монгол-Зөвлөлтийн зохиолчдын байгууллагын харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн анхны алхам болсон байна. Энэ нь шинэ социалист реализмын арга цаашдаа (дэлхийн II дайны дараа) Ази, Зүүн Европ, Америкийн социалист болон социалист чиг баримжаа бүхий орнуудын уран зохиолын арга болж бүхэл бүтэн системийн хандлага болж өргөжсөн болно.

Монголын ардын хувьсгалын ялалтаас эхлээд улс төр-үзэл суртлын талаар бат бэх холбогдсон Монгол, Орос хоёр улсын хувьд өөрсдийн соёлын бодлогоо шийдэх асуудал тийм ч түвэгтэй хэцүү зүйл биш байжээ. 1930-аад оны сүүлээс Оросын соёлын бодлого монголын уран зохиолын салбарыг өөрийн үзэл суртлын нөлөө хүрээнд барьж байх сонирхол идэвхжиж, монголчууд ч өөрсдөө энэ замыг зөв хэмээн үзэж, өөрийн дотоодын уран сайхны ажилд системтэй нэвтрүүлэх бодлого явуулж, уран бүтээлчдийг онол арга зүйгээр хангахыг чармайж байсан нь цаашид МАХН, МХЗЭ, Монголын Зохиолчдын байгууллагын идэвхтэй үйл ажиллагаагаар дамжин хэрэгжиж, Дэлхийн II дайны дараагаас улам өргөжин социалист системийн орнуудын соёлын интеграци руу хөтлөгдөн орсон байна. Энэ бол одоогийн мухардан зогссон социалист реализмын онол, арга зүйн монгол хувилбар, хөгжлийн эрчимтэй үе шат байлаа. Тухайн үедээ социалист системийн орнуудад нийтээр дагаж мөрдөх боломжтой урлаг, уран зохиолын урлахуйн нийтлэг нэг онол, дагнасан нэг аргатай байх нийгэм, оюун санааны тааламжит нөхцлийг бүрдүүлсэн нь социалист реализмын шинэ хэв маягийн арга зүй цаашид олон улсын хүрээнд бүх талаар жигдрэн боловсрох, түүний нааштай сайн бүхий л ололтын үндсийг тогтворжуулснаараа социалист орнуудын шинэ урлагийн хөгжил дэвшилд яах аргагүй чухал ач холбогдолтой зүйл байлаа.

Энэ бүхний үндэс нь 1930-аад оны үеэс Монголын Хувьсгалт Уран Зохиолчдын Холбооноос явуулж байсан “Бүх дэлхийн ба ялангуяа СССР улсын уран сайхны хувьсгалт утга зохиолын туршлагыг ашиглах... орчин тойрны биет юманд нөлөөлөх арга болох нийгэм журмын аргын тухай тайлбарлах, таниулах ажлыг өргөнөөр явуулах” /5/ олон талт арга хэмжээний үр дүн байсныг хэлэх хэрэгтэй.

Судлагч Ч.Аръяасүрэн монголын уран зохиолд социалист реализм үүсч хөгжсөн үе шат, онцлогийг 1921-40 он бол “социалист реализмын үндэс суурь тавигдсан үе” /6/ гэж үзсэн байна. Үүний гол тулгуур нь “Монголын хувьсгалын феодализмыг эсэргүүцсэн үе үндсэндээ 1940 онд дуусчээ. Нэг талаар феодалын нийгмийн улс төр эдийн засаг, соёл, үйлдвэрлэлийн харилцааг устгаж, гадаадын худалдаа-мөнгө хүүлэх капиталыг шахан зайлуулсан, нөгөө талаар улс ардын аж ахуйд социалист салбар үүсч, капиталист биш замаар хөгжих бат үндэс бий болсон” /7/ гэсэн улс төрийн дүгнэлт дээр үндэслэжээ. Тэрээр Д.Нацагдоржийн шүлэг, өгүүллэг, Ц.Дамдинсүрэнгийн “Тологдсон хүүхэн”, С.Буяннэмэхийн “Малчин Товуудай”, Д.Цэвэгмидийн “Хоньчин Найдан”, “Болд Самбуу хоёр” зохиолыг социалист реализмын анхны зохиолууд гэж нэрлэсэн юм.

Харамсалтай нь судлагч, нэгдүгээрт: Нийгмийн оюуны салбарт хамаарах социалист реализмын хөгжлийн асуудлыг улс орны эдийн засгийн хөгжлийн үе шаттай механикаар холбон адилтгасан, хоёрдугаарт социалист реализм онолын хувьд дөнгөж тодорхойлоод байсан ч уран бүтээлийн практикт бодот зүйл болоогүй байхад дээрх зохиолчдын туурвил зүйн хэв шинжийг нарийн задлан шинжлэлгүйгээр социалист

реализмын бүтээл гэж яаран дүгнэсэнд гол дутагдал нь оршино. Өөрөөр хэлбэл тэр үед Д.Нацагдоржийн уран бүтээлд шүүмжлэлт реализм, хувьсгалт романтизм, сентиментализм, абстракционизмын хэв шинжүүд, Д.Цэвэгмидийн бүтээлд натураль-реализмын, Ц.Дамдинсүрэнгийн уран бүтээлд ардын аман зохиолын үлгэрчлэн өгүүлэх арга, тэр ч бүү хэл хуулбарлах болон формаль хэлбэршлүүд, С.Буяннэмэхийн уран бүтээлд символчлол, натуралист арга барилын дүрслэлүүд тод хадгалагдсаар байсан юм.

Нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд 1943-45 оны үеэс социалист реализм бус харин “Реализм гэж юу вэ” /П.Хорлоо/ гэх зэрэг онолын чанартай анхны тайлбар өгүүллүүд нийтлэгдэж байсан байхад 1920-30-аад оны дээрх зохиолчдын бүтээл яагаад социалист реализмын зохиолууд болоод байгаа нь ойлгомжгүй зүйлсийн нэг нь юм. Ер нь урлагийн судалгаанд урлаг, уран зохиолын алив нэг бүтээл заавал ямар нэг тодорхой аргад захирагдаж /хамаарч/ байдаг гэсэн үзэл нэг хэсэг ноёрхож байлаа. Үнэн хэрэгтээ ямар нэг “изм”-д үл эрхшээгдэх тийм зохиол бүтээл байх хийгээд олон зүйлийн арга /бүр эсрэг тэсрэг аргууд ч/ нэгэн бүтээлд нэгдэн нийлэгжсэн байдаг зүй тогтлыг ч бид өдгөө мэддэг, ялгадаг болох шаардлагатай байна. Улс төр-үзэл сурталд баригдмал алив үндэстний уран зохиол судлалд л ямар нэг үзлийг хатуу барьж, асуудалд уян хатан аргаар бус хэт туйлширмал хатуу байр суурь ноёрхож байдаг зүй тогтолтой.

Судлагч, дэлхийн II дайны үеийн уран зохиолыг зөвлөлтийн ард түмний ялгуусан дүр, Зөвлөлт-Монголын найрамдал, эрх чөлөө, тусгаар тогтнол, түүхэн сэдэвт жүжгээр баяжсан гээд 1940-60 онд ХАА-г хоршоолох, үйлдвэржүүлэлтийн бодлого, атар эзэмшилтийг эхэлж, уран бүтээлд ангич, намч, ардач чанар, идэвхтэй зарчим үлэмж бэхжиж, уран зохиолын төрөл зүйл тасралтгүй өргөжин, амьдралыг уран сайхны үнэнээр илэрхийлэн, бичлэгийн арга барил, яруу найруулга олон талтай баялаг болж байгаа нь Д.Сэнгээгийн “Аюуш”, Д.Тарваагийн “Дамирангийнхан”, Ц.Уламбаярын “Энхтайвны манаа”, Д.Намдагийн “Гомпилын бага хүү”, Ч.Лодойдамба, Б.Ринчений тууж роман, өгүүллэг, Ч.Ойдов, Л.Ванган нарын жүжиг, Ч.Чимид, Б.Явуухулан, Д.Пүрэвдоржийн уран бүтээлд социалист реализм төлөвшин тогтож буй явц “тод үзэгдлээ” /мөн тэнд/. Ийм учраас 1948 онд томъёолсон “хувьсгалт реализм” гэдгийг “нийгэм журмын реализм” гэдэг томъёогоор солих хэрэгтэй. Учир нь нийгэм журмын реализм гэдэг томъёо бол манай орны нийгэм эдийн засгийн хөгжилт өөрчлөлт болоод манай утга зохиолын цаашдын зорилгод бүрэн тохиромжтой билээ” гэж МЗЭ-ийн II их хурлын заалтыг /9/ баталгаа болгон авч монголын социалист реализмын уран зохиолын хөгжлийн II үе шат гэж тодорхойлоод, 1960 оноос хойш үеийг “БНМАУ жараад оноос хөгжлийнхөө шинэ үе болох социализм өрнүүн байгуулах замд орж ... социализмын материал техникийн баазыг байгуулж дуусгах” /10/ зорилт дэвшүүлсэнтэй холбон социалист реализмын хөгжлийн III үе шат гэж үзсэн юм. Энэ үечлэл нийгэм-эдийн засгийн хөгжлийн үеүүдийг нэлээд хатуу баримталсан учраас уран бүтээлийн хөгжлийн практик үйл явц, уран бүтээлийн аргын хувьсал, хөгжлийн асуудлыг он цагийн хувьд хэтэрхий хатуу заагласны дээр хөгжлийн уян хатан шинж, эерэг, сөрөг үзэгдлүүд хийгээд түүний дотоод тэмцэл, үзэл баримтлалуудын хоорондын мөргөлдөөн, шилжилтүүд, олон талт харилцан хамаарал, гадаад, дотоод бодот нөхцөл байдлыг авч үзээгүй юм. Түүнээс гадна тухайн үе шат бүрийн цаана бодот хүчин зүйл болж асан Зөвлөлтийн болоод социалист орнуудын уран зохиолын амьдралд гарч байсан шинэ үзэгдэл, үйл явц түүний гадаад нөлөөллийн учир зүйг харгалзаагүйгээрээ дутагдалтай болсон юм.

Ц.Хасбаатар, Л.Түдэв, С.Лувсанвандан, Г.Жамсранжав, Ц.Мөнх, Д.Цэнд, Ч.Арьяасүрэн зэрэг ахмад, дунд үеийн судлаачдын хоорондоо эрс ялгаатай мэт эдгээр ангилал, үечлэлүүд нь үнэн хэрэгтээ оноосон нэр томъёоны хувьд өөр өөр боловч агуулга, үндэслэл нь ижил байна. Өөрөөр хэлбэл 1921-40-өөд оны үеийг монголын үндэсний шинэ уран зохиолд социалист реализм хөгжих өвөрмөц түүхэн онцлог /бэлтгэл/ үе шат болох тухай судалгаанууд нь ЗХУ ба Европын социалист орнуудын судлагчдын үзэл онолд тулгуурласан учраас зохиол бүтээлд задлал хийхдээ их төлөв агуулга, үзэл санааны талыг нь голчлон анхаарч байснаас тухайн үеийн /1921-1948/ зохиол бүрээс “хувьсгалт утга санаа” нь ялгарч үзэгдээд тэр нь “хувьсгалт реализм” гэж нэг онцлог арга бүхий үе шат байж гэсэн дүгнэлтэд хөтлөн хүргээд байсан шиг санагддаг юм.

1920-иод оноос хойш Монголын Зохиолчдын анхдугаар их хурал хүртэлх үед зөвхөн сонгодог реализмын хуучин өв уламжлалаас эш улбаатай шинэ маягийн реалист бичлэгийн хэв маяг хувьсгалт агуулгаар баяжин, аажмаар нийгмийн хөгжлийн өөрчлөлтийг даган шинэ шинэ зарчим зүйгээр баяжиж, түүний зэрэгцээ реалист бус арга найруулгууд зэрэгцэн оршиж, тэдгээрийн зарчим зүй, дүр дүрслэлийн элементүүд ч тухайн зохиолуудын дотор нийлэг хэлбэрээр оршиж байсныг нарийвчлан судлах шаардлагатай байгаа юм.

Харин 1950-60-аад онд социалист реализм бодот зүйл болсныг хүлээх хэрэгтэй. Түүний үндсэн шинж тэмдэг болох нийгэм, ахуйн өөрчлөлт ба эгэл хүний ажил үйлс, санаа бодлын хувирал өөрчлөлт нэлээд гүнзгий тусах болж, цаашдаа социализм олон улсын системийн хандлагатай болохын хэрээр туульсын том төрөл роман, тууж болон жүжиг, кино урлагт нийгмийн хэв шинж бүхий идэвхтэй амьд баатрууд гол байранд дэвшин гарч, уран дүрийн үүрэг, дүр дүрслэлийн бодот шинж хангагдан ангич, ардач, намч зарчмууд уран сайхны практикт нэвтэрч, социализмын үеийн шинэ хүний зан төрх, ёс суртахууны онцлог ба өсөлт, дотоод зөрчил, социализмын бүтээн байгуулалтын гол илэрхийлэл болсон атар ба тариаланч, аж үйлдвэр ба ажилчин, хөдөө аж ахуй ба нэгдэлчин, хөдөлмөрийн сэхээтэн /нийгэм дэх ажил мэргэжлийн янз бүрийн давхрага, бүлэглэлийн төлөөлөгчид/-ийн төлөөлөл буй болон урлагт хүнлэг, энэрэнгүй, эх оронч үзэл санаа, баатарлаг дайчин уламжлал, ёс суртахууны шинэ хэв маяг хийгээд үндэсний хэлбэрт социалист агуулгыг бүрдүүлэх талаар туршлагажиж, социализм, цаашлаад коммунизмын төлөө гэсэн олон түмний нэгдмэл үзэл бодол нийгмийн үнэмшил итгэл болсноор уран бүтээлийн агуулгад төдийгүй хэлбэрт томоохон өөрчлөлт авчирсан билээ.

Урлаг, уран зохиолд социалист реализмын арга бүрэлдэхдээ монгол орны хөгжлийн ерөнхий түвшин, нийгэм улс төрийн ээдрээт амьдрал, аж ахуйн буурай хэвшил, уламжлалт оюуны соёлын үндэсний өвөрмөц онцлог зэргээс шалтгаалан 1921-1948 оныг хүртэл олон ургальч үзэл уралдсан, чөлөөт сэтгэлгээнд суурилсан олон арга бүхий шинэ уран зохиолын үндсийг тавьсан шинэ урлаг, уран зохиолын хувьд төдийгүй нийгмийн шилжилтийн анхдугаар түүхэн онцлог үе шат байв. 1950-60-аад онд социалист реализм онол арга зүйн хувьд төдийгүй практик туурвил зүйд төлөвшин бүрэлдэх хөгжлийн эрчимтэй үеийг туулж, 1960-аад оноос 1980-аад оны дунд үе гэхэд хөгжлийн оргил үедээ хүрсэн боловч цаашдын хөгжил нь онол, арга зүй, бичлэг сэтгэлгээний хувьд мухардалд орсон нь 1990-ээд оны нийгмийн ардчилсан хувьсгалын үйл явцаар илрэн гарч ирсэн юм.

1964 онд хуралдсан МЗЭ-ийн III их хуралд С.Удвалын тавьсан илтгэлд “Бид эхэн үед /1930-48 он бололтой Д.Г/ хувьсгалт, дараа нь социалист реализмын аргыг хэрэглэх тухай бүдүүвчлэн ярилцаж тэр шинэ аргад тохирох шинэ хэлбэрийг эрж олох талаар шамдсан зүйлгүй байлаа” /11/ “Шинэ баатрын дүрийг бүтээхэд мөн шинэ маягийн роман хэрэгтэй байсан юм. Одоо... өөр байдалд хөгжиж нэг шинэ шат ахиж байна” /мөн тэнд/, Монголч эрдэмтэн Л.К.Герасимович “Сүүлийн 10 жил бол монголын зохиолчдын уран бүтээлийн өрнөлтийн үе боллоо. Түрүүхэндээ /1940-50-иад он Д.Г./ утга зохиолын мөн чанарын тухай социалист реализмын тусгай зохиолуудад л дөнгөж ярьж болох байсан бол одоо үндсэндээ социалист реализм монголын утга зохиолын үндсэн арга болж байна /12/, нэрт монголч эрдэмтэн Л.И.Михайлов шинэ уран зохиолын /1921-1955 оны/ үечлэлдээ 1940-1955 оныг “социализм байгуулалтын төлөө Монголын ард түмний тэмцлийн уран зохиол” /13/ зэрэг дүгнэлтүүд бидний бодлыг улам үнэмшилтэй болгож байна. Энэ нь 1960-аад оноос өмнө социалист реализмын аргын зарчим бүхий зохиол огт байгаагүй гэсэн үг биш юм. Иймд зөвхөн зохиолчдын I, II их хурлуудын /1948, 1957 он/ тодорхойлсон “хувьсгалт”, “социалист” гэдэг тодотгол нэр томъёонд баригдан механикаар хэсэгчлэн үечилж болмооргүй байна.

Монголын уран зохиолын эхний 20 гаруй жилийн түүх бол уран бүтээлийн шинэ арга барил, шинэ хэлбэрийг нийгмийн хувьсгалт эргэлтийн түвэгтэй нөхцөл байдлын дунд эрж хайсан чөлөөт арга, чөлөөт эрэл хайгуулын он жилүүд байжээ. Энэ үеийг хуучин нийгмийн үеийн загварчлан тогтоосон уран зохиолын үлгэрчлэх, сургамжлах арга барилаас орчин цагийн хувьсгалт /хөрөнгөтний бус хөгжлийн чиг баримтлал бүхий/ ёсны уран зохиолд шилжих шилжилтийн үеийн уран зохиол гэж үзэлтэй. Энэ зурвас үе бол сэтгэлгээний ямар нэг хаалт хашлагагүй чөлөөт уран бүтээлийн эрэл хайгуулын үе байсныг бид дараа тодорхой өгүүлэх болно.

Бид өмнө социалист реализмын аргын онолын эх сурвалж, пролетарийн соёл, уран зохиолын идэвхтэй нөлөөлөл, түүний системийн хандлагыг тодорхой цаг үетэй /хурлын шийдвэр, дэвшүүлсэн зорилттой/ холбон тодорхойлж 1930-аад оны төгсгөл үе хүртэл лавтайгаар Оросын уран зохиол хүчтэй нөлөө үзүүлж чадаагүй гэж үзсэн билээ. Харин Зохиолчдын анхдугаар их хурлаас хойш социализм нэг, хоёр орны хүрэнээс хальж системийн шинжтэй болсноор Монголын уран зохиолд Зөвлөлтийн уран зохиолын нөлөө, оролцоо хүчтэй нэвтэрч, хүссэн ч хүсээгүй ч монгол зохиолчид түүнийг аялдан дагахаас аргагүй байдалд орсон байна. Үүнийг ЗХУ-ын тэргүүлсэн социалист орнуудын соёлын интеграци, коммунист ажилчны хөдөлгөөний эрх ашиг шаардаж байжээ. Энэ шаардлагууд тухайн үеийн нам төрийн болон зохиолчдын байгууллагын хурал зөвлөлгөөний тогтоол шийдвэрүүдэд тод туссан юм

Социалист реализм ба монголын шинэ үеийн уран зохиолын арга, хэлбэрийн талаар капиталист орнуудын нийгэм, түүх, уран зохиол судлалын салбарын монголч эрдэмтдийн зарим бодууштай санал дүгнэлт байнга гарч байсан ч манай судлаач, шүүмжлэгчид тэдгээрийг эрс эсэргүүцэн үгүйсгэж байсан нь мэдээж хэрэг хоёр системийн хоорондын улс төр, үзэл суртлын “хүйтэн дайны” үр дагавар гэж тайлбарлаж болох байх. Үзэл суртлын ийм байр суурь нь социалист урлаг, уран зохиолыг хөрөнгөтний империалистуудын “аюул, халдлага”-аас хамгаалах үзэл санааны илэрхийлэл /эсэргүүцэл/ болж байлаа.

Монголын уран зохиолын түүхэнд “Манай залуу зохиолчдын шилдэг төлөөлөгчид Зөвлөлтийн утга зохиолын жишээн дээр, түүний үндсэн арга социалист реализмын аргаас суралцсанаар өөрсдийн зохиолуудад ард түмний аж амьдрал, тэмцлийн эрхэм

эрмэлзлэгээ, түүнчлэн ардын аман зохиолын уламжлалыг хүний сэтгэлийг хөдөлгөх ойлгомжтой, юмыг дүрслэн үзүүлэх, гоо сайхны нь эзэмшиж чадах явдалд туслав” /14/ гэж зөвлөлтийн уран зохиолын нөлөө, ач тусыг магтан тэмдэглээд, харин Зөвлөлт-Монголын уран зохиолын харилцаа, тэдгээрийн харилцан нөлөөний асуудлаар Америкийн нийгэм судлаач Р.Рупен, Английн түүхч Ч.Баудений бичсэн үндэслэл таамаглалыг зэвүүцэн угтаж “Тэд Оросын соёлын интеграцид, социалист реализмын аргын нөлөөнд Монголын уран сайхны соёлын өвөрмөц шинж, өнгө нүүрээ алдсан юм” гэж үнэн байдлыг мушгин гуйвуулж байна хэмээн дургүйцээд Зөвлөлтийн шинэ урлаг “Монголын шинэ социалист урлагийн хөгжлийн нэг хүчин зүйл болсон байна”, энэ бол “Манай уран зохиолын үндэсний болон интернационалч зарчим” /мөн тэнд/ гэж тайлбарлаж байв. Үнэхээр Монгол-Зөвлөлтийн уран зохиолын харилцааны асуудал эхэн үедээ энгийн нөхөрсөг харилцаанд үндэслэсэн интернационалч хэв шинжтэй байсан бол цаашдаа хөрш зэргэлдээ орнуудын уран зохиолд үүсдэг жирийн харилцан нөлөөлөл бус тодорхой зорилго чиглэлтэй, нэг нь суралцах, нөгөө нь сургах харьцааны хэлбэрт шилжин орсныг цагаатгах ёсгүй.

Н.Конрадын “Янз бүрийн үндэстэнд утга зохиолын нэгэн төрлийн үзэгдэл бий болон хөгжихөд утга зохиолын харилцаа холбоо тодорхой үүрэг гүйцэтгэнэ. Гэвч тэр нь түүний зайлшгүй нөхцөл болох албагүй. Харин нэгэн маягийн утга зохиол бий болоход шийдвэрлэх нөхцөл бол нийгэм түүхийн хөгжлийн нэгэн шатнаа тэдгээр улс үндэстэн дэвшиж тэрхүү хөгжлийн илэрхийлэгдэх хэлбэр ойролцоо байх явдал болно” /15/ гэсэн дүгнэлт ч арай өөр агуулгыг илэрхийлж байгааг бид харж байна.

Орчин үеийн дэлхийн улс үндэстнүүдийн уран зохиол судлалд колониал /цолоньзацион/ хэв шинж гэдэг ойлголтыг өргөн хүрээтэй хэрэглэх болжээ. Улс орнуудын хоорондын харилцаа, хүч чадал, хөгжлийн түвшингийн тэгш бус байдлаас шалтгаалан нийгэм, улс төр, эдийн засгийн салбарт түрэмгийллийн онцгой гэмээр хэв маягууд үүсдэг бөгөөд энэхүү “чимээгүй” колоничлолын нөхцөл байдлаас улбаалан “оюун санааны хүрээнд нэвчин шингэсэн колониал хэв шинжийн онцгой илрэлүүдийг /мэдрэмж/ тухайн “буурай” /колони/ үндэстний судлагчид гол төлөв хоцрогдлоос гарах дөт зам, их гүрний “тусламж дэмжлэг”, “харилцан нөлөөлөл”, “найрамдлын”, “интеграцийн”, “глобалчлолын” шинж тэмдэг гэж итгэсэн байдаг” /Р. Steiner. A.Memopoetics. Cornell Univ. London. P 167/ хийгээд колоничлогч нь улс төр, нийгмийн салбарт хялбархан тогтоож чадсан ноёрхлоо тухайн үндэстний соёл урлаг, оюун санааны амьдралд шууд тогтоож чаддаггүй учраас соёл, урлагийн салбарт өнгөц харах юм бол хүлээн авч болохуйц уян хатан гэмээр бодлогыг явуулан аажмаар тухайн үндэстний ард иргэдийн бодол санааг өөриймчлөх, бичиг үсэг, хэл, туурвил зүйн үндэсний уламжлалыг далдуур саармагжуулах замаар нөлөөлөх бололцоог эрж хайхад хүргэдэг. Энэ нь үндэсний сэхээтэн, үндсэрхэг үзэлтнүүдийг тайвшруулж дасгадаг гэж үздэг эрдэмтэд ч байна. Иймэрхүү үзэл баримтлал Монгол-Зөвлөлтийн ах дүүгийн харилцааны учир утгад тохирохгүй гэж үзлээ ч гэсэн ерөөсөө монголчууд бусдыг колоничилж, өөрсдөө ч колоничлогдож явсан ард түмний хувьд өөрийн соёл, утга зохиол судлалд энэ асуудлыг тавьж гүнзгийрүүлэн судлах шаардлага нэгэнт бий болжээ.

Уран зохиол судлагч Г.Жамсранжав гуай “Монголын шинэ уран зохиолд социалист реализм үүсэн бүрэлдэж, хөгжин мандсан” нийгмийн гол үндэс бол “Их зөвлөлтийн... социализм, коммунизмын туршлагыг хөгжлийнхөө маргааш болгож ирсэн манай орны ардчилсан хувьсгал, социалист байгуулалт мөн” /16/ гэж баталж

байна. Гэтэл барууны түүхч, судлаачид социалист реализм бол “зөвлөлтөөс монголд экспортлон нэвтрүүлсэн зүйл бөгөөд монгол шинэ урлаг нь жинхэнэ уран сайхны эсрэг “намын тасархай” бодлогын зэвсэг болсон” /17/ хэмээн бүр эсрэг дүгнэлт хийж байсан нь ердийн нэг гүтгэлэг байгаагүй байж мэдэх юм. Учир нь Зөвлөлтийн зохиолчид монголын “залуу уран зохиолчдод” заавар зөвлөлтөө өгч, манай зохиолчид тодорхой арга замыг олоход туслахыг хүсэж байсан баримт олон бөгөөд бас социалист реализм монголын үндэсний уран зохиолын уламжлалтай бичлэг, сэтгэлгээ, дүр, арга найруулгатай хэрхэн холбогдох вэ гэх мэтийн түвэгтэй олон асуудал хуримталжээ. Бид энэ асуудлаар хөрөнгөтний үзэл сурталчидтай нийлж байгаа хэрэг огтхон ч биш бөгөөд гагцхүү судалгааны баримтаар бий болсон дүр төрхийг төсөөлөн бодоход ийм юм.

Монголын шинэ уран зохиолын хөгжлийн эхэн үед монголын зохиолчдод социализм, реализм, уран зохиолын орчин үеийн онолын төсөөлөл, хувьсгалт соёл урлаг гэх мэтийн ойлголт маш бүрхэг байсныг доорх ганц баримт маш тодорхой харуулдаг. 1931 онд “Манай уран зохиолын гол хэлбэр нь үндэсний байхын хамт өнгө хэлбэр нь ажилчин зарц нарын байх тул үнэхээр Горькийн бүтээлийн хэлбэр нь манай уран зохиолчдод үлгэр жишээ даруй мөн” гэж “Үнэн” /1931. № 173/ сонин нийтэлж байв. Үүнээс харахад мөнөөхөн “үндэсний хэлбэр”-ийн асуудал ч ойлгомжгүй болдог юм.

Монголын нийгмийн амьдралд гарсан өөрчлөлтүүдийн мөн чанар, үндэсний өв уламжлал ба социализм, хөдөө аж ахуйн хоршоолол, нүүдлийн ба суурьшмал соёл иргэншлийн холбоо хамаарал болон бусад олон асуудлаар Ж.Мерф. Г.Паак, Р.Рупен, У.Уайтанг, Ч.Бауден, Н.Кнужсон нар Гадаад монгол буюу БНМАУ-ын нийгмийн дэвшил дэх Зөвлөлтийн оролцоо, нөлөөний асуудлыг маш хурц шүүмжилж байсан юм. Жишээ нь Ч.Бауден “Социализм-үндэсний уламжлалт зүйлд харш болох, Францын Н.Шапуй “Хот хөдөөгийн ялгарлын үндэс социализмд бий”, Р.Рупен “Монголын ард түмний үндэсний хүсэл эрмэлзлэл балран унаж байгааг” /”XX зууны монголчууд”/ анхааруулж байсан нь өдгөө улам үнэмшилтэй болсоор байна. Ер нь францын С.Дарс “Монгол улс” /1979/, АНУ-ын Д.Эйкман “Чингис хааны тал нутаг” өгүүллүүддээ бичсэн Монгол-Зөвлөлтийн найрамдал, хувьсгал, нийгмийн сонголтын ирээдүйн хувь заяа, мөн чанарын тухай дүгнэлтүүд бодотой байсныг өнөөдрийн амьдрал улам ч тодорхой болгож байна.

Ер нь Зөвлөлт-Монголын уран зохиолын харилцаа холбоо, түүхэн нөлөөллийн асуудлыг зөвхөн уран зохиолын түүхийн хүрээнд бус улс төр, эдийн засаг, үзэл суртлын бүх хэлхээ холбоонд нэгдмэл байдлаар судлах нь чухал байна. Цаг үе түүхийн шинэчлэл, шинэ эрин үүнийг үндэсний судлаачдаас зүй ёсоор шаардаж байна. Улсын түүх, социализм, коммунизмын түүхэн хувь заяаны төгсгөл түүний үзэл суртлын хуурмаг халхавч ч өдөр ирэх тутам задран урагдаж, олон ургальч үзэл, ардчилал, чөлөөт сэтгэлгээний хөгжлийн эрчимтэй үйл явц ч үүнийг давхар шаардаж эхлэв.

Монгол-Зөвлөлтийн ард түмний сайн сайхан нөхөрлөл, харилцан туслалцаж түүхийн хүнд хэцүү цагт “нэг экипажид”, энхийн бүтээн байгуулалтад “нэг бригадад” хамтран ажиллаж, амьдарч явсан үүх түүхийн гэрэл гэгээг ийм судалгаа хийснээр унтраачихгүй нь ойлгожтой зүйл.

Гагцхүү бид социализмыг цор ганц зөв зам, хувиршгүй, өөрчлөгдөшгүй мөнхийн “диваажин” гэж итгэсэн метафизик үзэл хандлага маань монголын сурвалжит урлаг, соёл, уран сайхны хөгжлийг мухардмал байдалд хөтлөн оруулсныг өдгөө зөв байсан гэж хамгаалах ямар ч боломжгүй болжээ. Америкийн нэрт монголч эрдэмтэн Ж.Крюгер

“Монголын уран зохиол эрт үеэс нааш амьдрах хүчин чадал бүхий ард түмний авъяас билгийг илэрхийлсэн оюун санааны өсөн хөгжсөн хэрэгсэл байсан”, одоо энэ үндэстний уран зохиол “Зөвлөлтийн прагматизмын” нөлөөнөөс болоод аман зохиол судлагчид ч, хүн судлаачдад ч “сонирхогдох зүйлгүй болжээ” /Ж.Крюгер “БНМАУ” 270-271/ гэж бичсэн нь монгол үндэстний уран зохиолын өөрийн гэх өвөрмөц хэлбэр, өнгө төрхгүй, хувьсгалт үзэл сурталд гүн автсан, түүхэн уламжлалаас холдон зөвхөн “социализмын үзэл санаа”, “ядуу, дунд ангийн” эрх ашигт үйлчилдэг, нийтлэг бөгөөд чөлөөт уран бүтээлийн замаар бус харин “гаж үзэл санааны” уран зохиол болон хувьсаж байгаад эмзэглэсэн дүгнэлт байв. Мөн С.Дарс Монголын шинэ уран зохиолын хуримтлуулж буй туршлага Орос-Зөвлөлтийн уран зохиолын хүрээнд хэт явцуурч буйг шүүмжилж, Д.Эйкман социалист реализмын сул талыг маш гярхай мэдэрч “нааштай талаас нь авч үзэхэд уран сайхны арга хэрэглүүрийг сонгон авах эрх чөлөөний олон мянган жилийн уламжлалыг тун бага анхаардаг номлол” /“Монголын нийгэмлэгийн мэдээ” сэтгүүл 1966. 11-12/ гэж дүгнэсэн нь социалист реализмын сүйрлийн өөр нэг шалтгаан нь болно. Энэ нь үндэсний уламжлалт олон арга барилыг үгүй хийж, феодалын нийгмийн үеийн төр-иргэний болон шашны уран зохиолын асар баялаг уламжлалыг ялгаварлан гадуурхаж, зөвхөн “ардчилсан дэвшилтэт” хэмээх уран зохиолын өчүүхэн хэсэгт нааштай хандаад, аман зохиолын туршлагыг хуучирсанд тооцож ирсэн Монголын орчин үеийн уран зохиолын түүхээр нотлогдох юм. Энэ бүгдээс шалтгаалан өдгөө өөрийн үндэсний түүхэн уламжлал бүхий уран бүтээлийн олон арга найруулгыг мэдэхээ больж, нөгөө талаар дэлхийн уран сайхны сэтгэлгээний хөгжлийн түүхийн явцад боловсорсон шинэ арга, уран зохиолын реалист бус урсгал, чиглэлүүдээс үлэмж тасарчээ.

Хэдийгээр монголчууд “XX зууны уран сайхны гол шугам болсон социалист реализмын нарийн түвэгтэй, өргөн хүрээтэй аргыг... түүний төрсөн эцэг болох Зөвлөлтийн утга зохиолын туршлагагүйгээр эзэмшиж чадахгүй байсан” /18/ нь зарим талдаа үнэн ч “хүн төрөлхтний хуримтлуулсан уран сайхны сэтгэлгээний сор дээжтэй танил байж түүнээс нэгэн адил суралцахгүйгээр”/19/, үндэсний уран зохиолын туршлагыг харгалзахгүйгээр, шинэ арга, уран бүтээлийн чөлөөт эрэл, ололтыг уран бүтээлийн практикт нэвтрүүлэхгүйгээр дан ганц улс төржсөн реализмаар нийгмийн оюун санааны бүх эрэлт хэрэгцээг хангах боломжгүй байв. Иймээс ч социализмын үзэл суртлыг туг болсон социалист реализм аргыг тууштай баримталсан нь ЗХУ, социалист систем, социалист реализмын аль алины мухардлыг түргэтгэж, үүнд монголын нийгэм, соёл урлаг, уран зохиолын хувь заяа ч хамаарч социализмын уран сайхны систем задран мухардмал байдалд орсон байна.

Ном зүй

1. “МАХН-аас урлаг, утга зохиолын талаар гаргасан тогтоол шийдвэрүүд” УБ., 1967. 68-р тал
2. “Үнэн сонин” 1928.4.11.№ 38
3. “Монголын зохиолчдын 8-р их хурал” УБ., 1990. 8-р тал
4. “Ардын үндэсний эрх” сонин 1924.11.10. № 82
5. “Улсын төв архив” 1938. Фонд Хн 1053
6. Арьяасүрэн.А Монголын утга зохиол дахь социалист реализмын хөгжлийн үе шат. Социалист аж төрөх ёс ба уран зохиол. УБ., УХГ. 1980. 62-р тал
7. Цэдэнбал Ю. Социалист Монголын хөгжил дэвшлийн түүхэн замнал УБ., 1976. 226-227 тал
8. Цэдэнбал Ю. Социалист Монголын хөгжил дэвшлийн түүхэн замнал УБ., 1976. 226-227 тал
9. “Монголын зохиолчдын 2-р их хурал” УБ., 1957
10. Арьяасүрэн.А Монголын утга зохиол дахь социалист реализмын хөгжлийн үе шат. Социалист аж төрөх ёс ба уран зохиол. УБ., УХГ. 1980
11. “Монголын зохиолчдын 3-р их хурал” УБ., 1964
12. Герасимович.Л.К Литература Монгольской народной республики (1921-1964) Л. 1965., 1981. 137-р тал
13. Михайлов.Г.И Очерк истории современной монгольской литературы. АН СССР. М. 1955. 191-р тал
14. Монголын орчин үеийн уран зохиолын түүх. И боть. УБ., 1985. 27-р тал
15. Конрад.Н.И. Известия.АН СССР. Отделение литературы и языка. ХҮ1.т. Вып 1У. 293-р тал
16. Жамсранжав.Г. Зэвсэг нэгтний тухай тэмдэглэл. УБ., 1972.. 216-р тал
17. Вопросы литературы. 1970 №9, 1963 №2, 1991 №1-6
18. Түдэв.Л Зөвлөлтийн уран зохиолын туршлага Монголын уран зохиолын хөгжилд. УБ., 1982.. 143-р тал
19. Цэдэв Д. Цаг үе утга зохиол. УБ., 1987. 91-р тал
- Цэдэв Д. Д.Нацагдоржийн өгүүлэлт зохиолд хийсэн зарим ажиглалт. УБ. /номд/

SUMMARY

Author analyzes the socialist realism, its development, political influence and rights and wrongs, which was the basic method of Mongolian literature and literary criticism during the 20th century. It's considered that political doctrine behind socialist realism was an international literary movement.